



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Утас: 32-03-92, Факс: (976-11) 31-14-71
<http://www.mongolbank.mn>

2023.12.26 № A-1/1096
танай _____-ны № _____-т


「МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ц.ЦЭРЭНПУНЦАГ ТАНАА

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасны дагуу Эрдэнэсийн сангийн 2023 оны төсвийн гүйцэтгэл, 2024 оны төсвийн төслийн танилцуулга, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлж байна.

Эрдэнэсийн сангийн 2023 оны үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээ сангийн зарлагын гүйцэтгэлийн тайлан, 2024 оны үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын төсвийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж өгөхийг Танаас хүсье.

Хавсралт 14 хуудас.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

1523032507

2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн
албан тоотын хавсралт

ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ҮНДСЭН САНГИЙН ОРЛОГО, ҮНДСЭН
БОЛОН ГҮЙЛГЭЭ САНГИЙН ЗАРЛАГЫН 2024 ОНЫ
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү тайланг боловсруулахдаа Эрдэнэсийн сангийн тухай хууль, Улсын Их Хурлын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээ сангийн зарлагын 2023 оны төсөв”, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар зөвлөмж, Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны журам, Дурсгалын зоос үйлдвэрлүүлэх, хадгалах, хамгаалах, зарцуулах журам, Үнэт металлын үйл ажиллагааны журам, Эрдэнэсийн сангийн мэргэжлийн зөвлөлийн хурлын шийдвэр, Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын тайланг үндэслэв.

Хоёр. Эрдэнэсийн сангийн төсвийн гүйцэтгэл

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн шинэчлэсэн найруулгын 4.6-д Үндсэн сангийн байнгын хэсэгт байх түүх, соёлын дурсгалт зүйл нь хосгүй үнэт зэрэглэлтэй байна гэж заасны дагуу Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн бүртгэлийг шинэчлэн бүртгэсэн. Үндсэн сангийн байнгын хэсэгт түүх соёлын хосгүй үнэт зэрэглэлтэй эд зүйлсийг бүртгэж байнгын бус хэсэгт хуульд заасны дагуу олон улсын жишгээр цэвэршүүлсэн үнэт металл, засаж өнгөлсөн эрдэнийн чулуу, түүх, соёлын үнэт дурсгалт зүйл, үнэт болон бусад металаар хийж нөөцөд авсан зоосыг бүртгэсэн.

Эрдэнэсийн сангийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан Монголбанкны Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны журам, Үнэт металлын үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталсан. Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтын дагуу Харуул хамгаалалтын журмын төслийг боловсруулан Төрийн тусгай хамгаалалтын газраас санал авч тусган батлуулахаар хүргүүлсэн.

Улсын Их Хурлын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээ сангийн зарлагын 2023 оны төсөв”-ийг батлагдсан бөгөөд дараах гүйцэтгэлтэй байна. /Хүснэгт 1/.

Хүснэгт 1. Эрдэнэсийн сангийн 2023 оны төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл /сая төгрөгөөр/

	Үндсэн сангийн орлого	Хэмжих нэгж	Батлагдсан	Гүйцэтгэл
1	1.1. Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлс, байгалийн төрц худалдан авах, урлагийн бүтээл захиалан хийлгэх, археологийн болон бусад судалгааны байгууллагатай хамтран ажиллах,	сая.төгрөг	2,000	110.0
	1.2. Чингис хаан баримал, алтан тамганы хамт бүтээлгэх	сая.төгрөг	8,000	7,858
2	Монголбанкны зөвшөөрлөөр цутгуулсан франчайз болон дурсгалын зоосны дээж	ширхэг	200	208
3	Чингис хаан хүрэл баримал, алтан тамгын хамт	цогц	1	-

